

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан.....	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.11	Шилэн дансны мэдээлэл	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал.....	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
5	Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт.....	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
УМХГ	Улсын мэргэжлийн хяналтын газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.02.25 № 06/339
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

БУЯНТ-УХАА БООМТ ДАХЬ ХИЛИЙН
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН АЛБАНЫ
ДАРГА Б.ОТГОНЦЭЦЭГ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Буянт-Ухаа боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Буянт-Ухаа боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Буянт-Ухаа боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

- Хөшигийн хөндий дэх олон улсын нисэх онгоцны буудал ашиглалтанд орох хугацаа тодорхойгүй байхад Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2018 оны 5 дугаар сарын 22-ний өдрийн А/74 тоот тушаалаар 36 орон тоо нэмж 49,890.6 мянган төгрөгийн төсвийг үргүй зарцуулсан
- Ажилчдын ээлжийн амралтыг тооцохдоо унаа, хоолны мөнгө 2.018.3 мянган төгрөгийг дундаж цалинд оруулан тооцож олгосон зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, эрх ба үүрэг, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1 Оршил

Буянт-Ухаа боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Буянт-Ухаа боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны дарга Б.Отгонцэцэг Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Буянт-Ухаа боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Буянт-Ухаа боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 2 дугаар сарын 11-нээс 2019 оны 2 дугаар сарын 24-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Б энд С аудит ХХК-ийн ахлах аудитор Д.Дашхорлоо, аудитор Д.Заяажаргал нар хариуцаж хэрэгжүүлэв.

Буянт-Ухаа боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газрын санхүүгийн аудитын газарт 2019 оны 1 дүгээр сарын 25-ны 1/37 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Буянт-Ухаа боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго: Буянт-Ухаа боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын алба нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Хүн, мал, амьтан, ургамалын эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөтэй бодис, бараа бүтээгдэхүүн, цацраг идэвхитэй бодис, эх үүсгэвэр агаарын хилээр нэвтрүүлэхгүй байх
- Агаарын хилээр эрсдэл өндөртэй халдварт өвчнүүд, гадаад дотоод хорио цээртэй ургамлын зүйл, хөнөөлт хортон шавьж, мэрэгч нэвтрүүлэхгүй байх
- Агаарын хилийн бүс зурвасын орчин “Агаар, ус, хөрс эрүүл мэндийн аюулгүй байдлыг хянах”
- Төрийн хяналт шалгалтыг “Төрийн үйлчилгээний ажилтай хослуулж хэрэгжүүлэх” ажлыг холбогдох хууль тогтоомжын хүрээнд хийж гүйцэтгэх
- Агаарын хилийн болон нислэгийн аюулгүй байдлыг хангахад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх
- Экипажийн бие бүрэлдэхүүн зорчигчийг элдэв халдвар, хордлогоос урьдчилан сэргийлэх
- Олон улсын нислэгийн үйл ажиллагаатай шууд холбогддог хяналтын объектууд, тэдгээрт ажиллагсдын эрүүл ахуй, ариун цэвэр, зорчигчдын хоол, хүнсний аюулгүй байдлыг хангуулах.

Буянт-Ухаа боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны үйл ажиллагааны чиглэл: Үүнд:

- Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналт
- Ариутгал, халваргүйтгэл
- Ургамал хорио цээр, чанарын хяналт
- Мал эмнэлгийн хяналт
- Хүнсний чанар, стандартын хяналт
- Эм био бэлдмэлийн хяналт
- Байгаль орчны хяналт
- Цацрагийн хяналт
- Стандарт чанарын хяналт гэсэн үндсэн чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна

Буянт-Ухаа боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Буянт-Ухаа боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын хилийн тухай хууль
- Ариун цэврийн тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Татварын багц хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Буянт-Ухаа боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Буянт-Ухаа боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын алба санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн Интерактив компанийн “Emerald 5.0” програм хангамж ашигладаг байна.

Буянт-Ухаа боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Буянт-Ухаа боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 12 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 3 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт үйл ажиллагааны зардлын дүнгийн 2 хувиар сонгов.

Буянт-Ухаа боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын алба нь 100 хувь улсын төсвөөс санхүүждэг учир нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь санхүүгийн тайланд нөлөөлөх эрсдэл дунд гэж үзсэнтэй холбоотой юм.

Буянт-Ухаа боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны 2018 оны нийт зардал 1,629,520.0 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 32,590.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь зардлын дансанд эрсдэл дунд гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 АУДИТЫН ЯВЦАД ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 12 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 8 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэлээ.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	56,023.2	Өртөгөө нөхсөн үндсэн хөрөнгийг шийдвэрлүүлэх
2	Төлбөрийн акт тогтоосон	2	2.018.3	Ажилчдын ээлжийн амралтыг тооцохдоо унаа хоолны мөнгийг дундаж цалинд тооцож олгосон

3	Албан шаардлага өгсөн	1	49,890.6	Төсвийн үргүй зардал гаргасан
	Дүн	4	107,932.1	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Хөшигийн хөндий дэх олон улсын нисэх онгоцны буудал ашиглалтанд орох хугацаа тодорхойгүй байхад Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2018 оны 5 дугаар сарын 22-ний өдрийн А/74 тоот тушаалаар 36 орон тоо нэмэгдүүлж 49,890.6 мянган төгрөгийн төсвийг үргүй зарцуулсан
 - **Шийдвэрлэсэн:** Албан шаардлага хүргүүлэв.
2. Ажилчдын ээлжийн амралтыг тооцохдоо унаа хоолны мөнгө 2.018.3 мянган төгрөгийг дундаж цалинд тооцож олгосон
 - **Шийдвэрлэсэн:** Акт тогтоохоор шийдвэрлэв.

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

1. Байгууллагын даргын 2016 оны 12 дугаар сарын 28-ний өдрийн Б/115 дугаар тушаалаар ажилаас чөлөөлөгдсөн ажилтан шүүхийн байгууллагад нэхэмжлэх гаргасныг шүүх үндэслэлтэй гэж үзэн ажилд эргүүлэн тогтоож ажилгүй байсан хугацааны цалин 7,333.1 мянган төгрөгийг төсвөөс олгосон нь Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5 “Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй” гэж заасантай нийцэхгүй байна.
2. 2018 оны 12 дугаар сард өртөгөө нөхсөн үндсэн хөрөнгө 92,626.7 мянган төгрөгийг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлсэн эсэх, зэрэг асуудлуудыг дараагийн аудитаар авч үзэх

2.10 ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Буянт-Ухаа боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 29 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 1,457,121.4 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 1,141,152.4 мянган төгрөг буюу 78.3 хувьтай байна.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Буянт-Ухаа боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын алба Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар тус байгууллагын 2017 оны санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулсан байна.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Буянт-Ухаа боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Буянт-Ухаа боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.1.1 Илрүүлэлт

Тус байгууллагын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд өртгөө нөхсөн үндсэн хөрөнгө 56,023.2 мянган төгрөгийг Төрийн өмчийн хорооны 2012 оны 44 дүгээр тогтоолын 5-д заасны дагуу зохих байгууллагаар шийдвэрлүүлэх.

Энэ нь үнэн зөв байх, оршин байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.1.2 Эрсдэл

Холбогдох хууль тогтоомж хэрэгжээгүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж

Өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх, хөрөнгийн үнэлгээ хийлгэх

3.1.4 Байгууллагаас ирсэн хариу тайлбар:

Актлуулахаар тооллогын комиссын дүгнэлт гарсан

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 сарын 31-ны өдрөөр дуусгавар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>31,385,822.41</u>	<u>114,848,938.24</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
33	АВЛАГА	-	23,583.17
335	Бусад авлага	-	23,583.17
3351	Байгууллагаас авах авлага		23,583.17
3352	Хувь хүмүүсээс авах авлага		
35	БАРАА МАТЕРИАЛ	31,385,822.41	114,825,355.07
351	Түүхий эд материал	6,011,088.32	5,475,968.04
35110	Тусгай зориулалттай материал		
35130	Эм боох материал	6,011,088.32	5,475,968.04
35200	Дуусаагүй үйлдвэрлэл		
35300	Бэлэн бүтээгдэхүүн		
354	Хангамжийн материал	25,374,734.09	109,349,387.03
35410	Бичиг хэргийн материал	4,775,919.96	6,258,384.90
35420	Аж ахуйн материал	177,300.00	2,297,521.00
35430	Сэлбэг хэрэгсэл		
35440	Түлш, шатах тослох материал	2,406,453.00	10,328,078.00
35450	Барилгын засварын материал		
35460	Хүнсний материал		
35470	Бусад хангамжийн материал	18,015,061.13	90,465,403.13
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>550,958,006.51</u>	<u>406,997,360.64</u>
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	550,958,006.51	406,997,360.64
391	Газар		
392	Биет хөрөнгө	550,958,006.51	406,997,360.64
39203	Авто-тээврийн хэрэгсэл	36,443,847.00	74,443,847.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-36,443,847.00	-73,308,251.89
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,171,746,997.72	1,214,513,212.14
39206	Хуримтлагдсан элэгдэл	-733,458,790.77	-943,893,313.02
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	24,643,166.74	68,077,191.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	-21,612,057.81	-23,618,159.42
39214	Бусад үндсэн хөрөнгө	186,718,903.00	186,718,903.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-77,080,212.37	-95,936,068.57
39301	Програм хангамж	1,002,478.00	1,002,478.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,002,478.00	-1,002,478.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>582,343,828.92</u>	<u>521,846,298.88</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	=	=
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>582,343,828.92</u>	<u>521,846,298.88</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	582,343,828.92	521,846,298.88
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	287,715,051.72	287,715,051.72

Буянт-Ухаа боомт дахь мэргэжлийн хяналтын албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51101	Өмч: - төрийн	287,715,051.72	287,715,051.72
512	Хуримтлагдсан үр дүн	285,692,829.43	225,195,299.39
51210	Өмнөх үеийн үр дүн	-79,387,163.09	285,692,829.43
51220	Тайлант үеийн үр дүн	365,079,992.52	-60,497,530.04
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	8,935,947.77	8,935,947.77
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>582,343,828.92</u>	<u>521,846,298.88</u>

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 сарын 31-ны өдрөөр дуусгавар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,240,137,943.60	1,569,022,538.16
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	510,092,043.60	111,901,138.16
120	Нийтлэг татварын бус орлого	510,092,043.60	111,901,138.16
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	510,092,043.60	111,855,138.16
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	88,548,900.00	104,955,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		514,800.67
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	421,543,143.60	6,385,337.49
120009	Бусад орлого		46,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	730,045,900.00	1,457,121,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	718,865,900.00	1,457,121,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	718,865,900.00	1,457,121,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,180,000.00	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	11,180,000.00	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	874,634,503.20	1,629,520,068.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	874,634,503.20	1,629,520,068.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	769,196,460.69	1,175,710,191.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	560,251,282.11	700,629,596.37
210101	Үндсэн цалин	534,990,882.11	633,652,396.37
210102	Нэмэгдэл	11,641,200.00	35,765,600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,514,000.00	20,955,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	6,105,200.00	10,256,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,200,582.00	84,295,468.25
210201	Тэтгэврийн даатгал	66,200,582.00	48,262,368.25
210202	Тэтгэмжийн даатгал		9,008,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		7,206,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал		1,801,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал		18,016,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,580,000.00	43,846,450.00
210301	Гэрэл, цахилгаан	735,300.00	958,500.00
210304	Байрны түрээс	39,844,700.00	42,887,950.00
2104	Хангамж, бараа материалын зардал	43,555,657.17	37,845,801.23
210401	Бичиг хэрэг	9,455,110.67	12,524,487.35
210402	Тээвэр, шатахуун	8,480,403.00	11,159,323.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,290,434.00	5,405,277.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,998.00	4,663,214.00
210408	Бараа материал акталсны зардал	23,315,711.50	4,093,499.88
2105	Нормативт зардал	6,094,641.84	5,654,098.31
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,843,842.78	3,351,182.32
210502	Хоол, хүнс	2,250,799.06	2,302,915.99

Буянт-Ухаа боомт дахь мэргэжлийн хяналтын албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,504,228.51	52,201,106.80
210604	Урсгал засвар	2,504,228.51	52,201,106.80
2107	Томилолт, зочны зардал	-	702,000.00
210702	Дотоод албан томилолт		702,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	723,850.00	8,558,010.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		4,248,700.00
210803	Даатгалын үйлчилгээ	226,750.00	167,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	134,000.00	104,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	363,100.00	4,015,410.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	49,286,219.06	241,977,660.36
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,900,000.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,352,900.00	6,143,535.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	44,033,319.06	235,834,125.36
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	105,438,042.51	453,809,876.88
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,315,083.51	
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	1,315,083.51	
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,574,059.00	32,885,904.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,220,000.00	958,414.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		31,927,490.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,354,059.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	88,548,900.00	420,923,972.88
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	88,548,900.00	420,923,972.88
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>365,503,440.40</u>	<u>-60,497,530.04</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	423,447.88	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	423,447.88	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-423,447.88	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>365,079,992.52</u>	<u>-60,497,530.04</u>

АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 сарын 31-ны өдрөөр дуусгавар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>841,668,119.00</u>	<u>1,562,076,400.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	90,164,797.00	104,955,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	90,164,797.00	104,955,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	90,164,797.00	104,955,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	88,548,900.00	104,955,000.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	1,615,897.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	751,503,322.00	1,457,121,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	718,865,900.00	1,457,121,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	718,865,900.00	1,457,121,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,180,000.00	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	11,180,000.00	
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	21,457,422.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	21,457,422.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>841,668,119.00</u>	<u>1,474,046,400.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	841,668,119.00	1,474,046,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	709,826,713.49	1,018,194,737.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	562,874,835.49	692,555,047.12
210101	Үндсэн цалин	479,338,835.49	625,577,847.12
210102	Нэмэгдэл	42,924,000.00	35,765,600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,297,000.00	20,955,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	18,315,000.00	10,256,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,056,400.00	91,701,757.00
210201	Тэтгэврийн даатгал	62,056,400.00	55,668,657.00
210202	Тэтгэмжийн даатгал		9,008,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		7,206,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал		1,801,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал		18,016,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,580,000.00	43,418,000.00
210301	Гэрэл, цахилгаан	735,300.00	958,500.00
210304	Байрны түрээс	39,844,700.00	42,459,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,815,634.00	41,082,613.00
210401	Бичиг хэрэг	5,423,200.00	11,675,876.00
210402	Тээвэр, шатахуун	10,071,000.00	18,922,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,290,434.00	5,833,727.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,031,000.00	4,650,610.00
2105	Нормативт зардал	6,885,400.00	5,722,810.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,635,400.00	3,472,810.00
210502	Хоол, хүнс	2,250,000.00	2,250,000.00

Буянт-Ухаа боомт дахь мэргэжлийн хяналтын албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,564,600.00	127,714,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		2,300,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		73,610,200.00
210604	Урсгал засвар	2,564,600.00	51,803,800.00
2107	Томилолт, зочны зардал	-	702,000.00
210702	Дотоод албан томилолт		702,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,631,447.00	8,976,010.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		4,248,700.00
210803	Даатгалын үйлчилгээ	226,750.00	167,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	134,000.00	104,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	370,697.00	4,015,410.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	900,000.00	418,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,418,397.00	6,322,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,515,897.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,902,500.00	6,322,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	131,841,405.51	455,851,662.88
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,315,083.51	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	1,315,083.51	
2132	Бусад урсгал шилжүүлэг	41,977,422.00	34,927,690.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	21,457,422.00	
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,220,000.00	3,000,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		31,927,490.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,300,000.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	88,548,900.00	420,923,972.88
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	88,548,900.00	420,923,972.88
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	≡	<u>88,030,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	88,030,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	88,030,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	88,030,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		88,030,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	≡	<u>-88,030,000.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 сарын 31-ны өдрөөр дуусгавар болсон тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	287,715,051.72	8,935,947.77	285,692,829.43		582,343,828.92
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	287,715,051.72	8,935,947.77	285,692,829.43	0.00	582,343,828.92
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	287,715,051.72	8,935,947.77	285,692,829.43	0.00	582,343,828.92
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	287,715,051.72	8,935,947.77	285,692,829.43	0.00	
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	287,715,051.72	8,935,947.77	285,692,829.43	0.00	582,343,828.92
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			-60,497,530.04		-60,497,530.04
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	287,715,051.72	8,935,947.77	225,195,299.39	0.00	521,846,298.88

АУДИТ ХИИСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 сарын 31-ны өдрөөр дуусгавар болсон тайлан

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,457,121,400	1,141,152,427.12	127.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,457,121,400.00	1,141,152,427.12	127.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,422,193,700.00	1,106,224,737.12	128.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	914,119,300.00	692,555,047.12	131.99
210101	Үндсэн цалин	847,142,100.00	625,577,847.12	135.42
210102	Нэмэгдэл	35,765,600.00	35,765,600.00	100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,955,000.00	20,955,000.00	100.00
210104	Урамшуулал			
210105	Гэрээт ажлын хөлс	10,256,600.00	10,256,600.00	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	108,913,900.00	91,701,757.00	118.77
210201	Тэтгэврийн даатгал	72,880,800.00	55,668,657.00	130.92
210202	Тэтгэмжийн даатгал	9,008,300.00	9,008,300.00	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,206,600.00	7,206,600.00	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,801,700.00	1,801,700.00	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	18,016,500.00	18,016,500.00	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,074,500.00	43,418,000.00	129.15
210301	Гэрэл, цахилгаан	1,038,500.00	958,500.00	108.35
210304	Байрны түрээс	55,036,000.00	42,459,500.00	129.62
2104	Хангамж, бараа материалын зардал	63,915,700.00	41,082,613.00	155.58
210401	Бичиг хэрэг	13,132,600.00	11,675,876.00	112.48
210402	Тээвэр, шатахуун	29,751,000.00	18,922,400.00	157.23
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,841,500.00	5,833,727.00	271.55
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	540,000.00		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,650,600.00	4,650,610.00	100.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал			
2105	Нормативт зардал	18,685,400.00	5,722,810.00	326.51
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	16,435,400.00	3,472,810.00	473.26
210502	Хоол, хүнс	2,250,000.00	2,250,000.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл			
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	218,870,800.00	215,744,000.00	101.45
210601	Багаж, техник, хэрэгсэл	93,000,000.00	90,330,000.00	102.96
210602	Тавилга			
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	74,000,000.00	73,610,200.00	100.53
210604	Урсгал засвар	51,870,800.00	51,803,800.00	100.13

Буянт-Ухаа боомт дахь мэргэжлийн хяналтын албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2107	Томилолт, зочны зардал	916,400.00	702,000.00	130.54
210701	Гадаад албан томилолт			
210702	Дотоод албан томилолт	916,400.00	702,000.00	130.54
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах			
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34,375,200.00	8,976,010.00	382.97
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,076,400.00	4,248,700.00	496.07
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	-	
210803	Даатгалын үйлчилгээ	769,100.00	167,400.00	459.44
210804	Тээврийн хэрэгслийн татвар	202,000.00	104,500.00	193.30
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,705,700.00	4,015,410.00	117.19
210807	Газрын төлбөр			
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж			
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	7,300,000.00	418,000.00	1,746.41
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,322,500.00	6,322,500.00	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал			
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,322,500.00	6,322,500.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,927,700.00	34,927,690.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,927,700.00	34,927,690.00	100.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,000,200.00	3,000,200.00	100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,927,500.00	31,927,490.00	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,457,121,400.00	1,141,152,427.12	127.69
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,457,121,400.00	1,141,152,427.12	127.69
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,457,121,400.00	1,141,152,427.12	127.69
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	119.00	92.00	129.35
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	111.00	84.00	132.14
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	6.00	8.00	75.00
650010	Гэрээт ажилтан	2.00	-	

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2019.02.20	Аудитын нэр: Буянт-Ухаа боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн	Аудитын код: САГ-2019/271/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Буянт-Ухаа боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын алба	Мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Хөшигийн хөндий дэх олон улсын нисэх онгоцны буудал ашиглалтанд орох хугацаа тодорхойгүй байхад МХЕГ А/74 тоот тушаалаар шинээр 32 орон тоог нэмэгдүүлж төсвийн үргүй зардал гаргасан	49,890.6	Албан шаардлага хүргүүлэх	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Б.Отгонцэцэг П.Оюунгэрэл
2	Ажилчдын ээлжийн амралтыг тооцохдоо унаа хоолны мөнгийг дундаж цалинд тооцож олгосон, шүүхийн шийдвэрээр ажилгүй байсан хугацааны цалинг төсвөөс олгосон	2,018.3	Акт тогтоохоор шийдвэрлэв	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Б.Отгонцэцэг П.Оюунгэрэл
3	Өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх	56,023.2	Зөвлөмж өгөх	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Б.Отгонцэцэг П.Оюунгэрэл
	Дүн	107,932.1			

